



Оюу толгой ХХК

Орон нутгийн харилцаа

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

АГУУЛГА

1	ТАНИЛЦУУЛГА	4
1.1	Зорилго	4
1.2	Хэрэглээ	4
1.3	Эхлэх хугацаа	5
1.4	ХАРИУЦЛАГА БА УДИРДЛАГА	5
2	ХАМРАХ ХҮРЭЭ	6
2.1	Ерөнхий тойм	6
2.2	ОТ-н нөлөөллийн бүсэд орших бэлчээр, малчид	6
2.3	Энэхүү Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ	7
2.4	Бусад Удирдлагын төлөвлөгөөтэй давхацсан байдал	8
2.5	Хамтын оролцоонд түшиглэсэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй давхацсан байдал	9
3	АЛБАН ТУШААЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	11
3.1	Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх гол үүрэг хариуцлага	11
3.2	Удирдлагын төлөвлөгөөний удирдлага	12
3.3	Экосистемийн үйлчилгээний ажлын хэсэг	13
3.4	Гол уялдаа холбоо	14
4	ТӨСЛИЙН СТАНДАРТУУД	15
4.1	Монгол улсын холбогдох хууль тогтоомж	16
4.2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ) – ний шаардлагууд	16
4.3	ОТ болон Рио Тинтогийн холбогдох стандартууд	16
4.4	Холбогдох олон улсын стандарт, удирдамжууд	20
5.	УДИРДЛАГЫН ХЯНАЛТ	20
5.1.	БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ, АМЬЖИРГААГ ДЭМЖИХ СТРАТЕГИ (2017–2019).....	20
5.1.	БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ, АМЬЖИРГААГ ДЭМЖИХ СТРАТЕГИ (2020-2022).....	20
6.	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ	29
6.1.	Удирдлагын төлөвлөгөөг хянах, засвар оруулах	29
7.	ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ	29
7.1.	Хяналт шинжилгээний шаардлагын ерөнхий тойм.....	29
7.2.	Гүйцэтгэлийн гол үзүүлэлт	29
7.3.	Хяналт шинжилгээний гол үйл ажиллагаа	29
8.	СУРГАЛТ	31
8.1.	Ерөнхий тойм	31
8.2.	Танилцуулах болон давтан сургалт.....	31
9.	АУДИТ БА ТАЙЛАГНАЛ	31
9.1.	Дотоод аудит	31
9.2.	Хөндлөнгийн аудит.....	32
10.	ТАЙЛАГНАХ	32
11.	БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ	33

ХАВСРАЛТ 1. ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИ

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

ХҮСНЭГТ

Хүснэгт 1: Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийн тойм	9
Хүснэгт 2: Гол албан тушаалтан, үүрэг хариуцлага.....	11
Хүснэгт 3: Ажил үүргийн диаграмм	12
Хүснэгт 4: Бэлчээрийн менежмент, амьжиргааг дэмжих стратегийн хэрэгжилтийн хураангуй (2017 – 2019).....	24
Хүснэгт 5: Удирдлагын хяналт (2020-2021).....	24
Хүснэгт 6. 2020-2021 онд хэрэгжүүлэх үе шат	29
Хүснэгт 7: Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	30
Хүснэгт 8: Хяналт шинжилгээний арга хэмжээ.....	30

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

1 ТАНИЛЦУУЛГА

Энэхүү баримт бичиг нь Оюу толгой (ОТ) төслөөс гаргасан Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргаанд дэмжлэг үзүүлэх удирдлагын төлөвлөгөө болно. Тус удирдлагын төлөвлөгөөний баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013.

1.1 Зорилго

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь дараах зорилготой. Үүнд:

- Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, холбогдох менежментийн уялдаа холбоог тогтоох;
- Албан тушаал, үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- Энэхүү удирдлагын төлөвлөгөөтэй холбоотой төслийн стандартуудыг тодорхойлох;
- Энэхүү удирдлагын төлөвлөгөөтэй холбоотой Төслийн үүрэг амлалт, үйл ажиллагааны журам, удирдамж, зааварчилгааг тодорхойлох;
- Гүйцэтгэлийн гол үзүүлэлт зэрэг хяналт шинжилгээ, тайлагналын журмыг тодорхойлох;
- Сургалтын шаардлагыг тодорхойлох;
- Дагалдах материал, мэдээллийн лавлагааг гаргах.

1.2 Хэрэглээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд тусгасан шаардлагууд нь гэрээт туслан гүйцэтгэгчдийг оролцуулан ОТ-н бүх үйл ажиллагаанд тавигдана.

Удирдлагын төлөвлөгөөг Хөрөнгө оруулалтын гэрээ, Хамтын ажиллагааны гэрээ, ГТЗ-ийн Малчдын гомдол барагдуулах хоёр гэрээ, Рио Тинтогийн Орон нутаг, нийгмийн хариуцлагын гүйцэтгэлийн стандарт болон МУ-ын холбогдох хууль тогтоомжийн дагуу, Бэлчээрийн менежмент ба Малчдын амьжиргааг дэмжих стратегид үндэслэн боловсруулсан.

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих үйл ажиллагааны удирдлагын төлөвлөгөөний үндсэн зорилго нь бэлчээрийн тогтвортой менежмент, малчдын амьжиргааг дэмжих чиглэлээр хэрэгжих хөтөлбөрүүд болон энэ чиглэлээр орон нутгийн Засаг захиргаа, малчдын зүгээс гаргасан санал санаачлагад дэмжлэг үзүүлэхэд ОТ-н гүйцэтгэх үүрэг, оролцоог тодорхойлоход оршино.

Гэхдээ Бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх аливаа харилцаанд Монгол улсын төр, төрийн нэгж нь Монгол улсын Газрын тухай хуульд заасан үндсэн эрх, үүрэгийн дагуу тэргүүлэгчийн үүрэгтэй оролцоно.

Тодруулбал, энэхүү төлөвлөгөө нь ОТ компанийн үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийн малчидын амьжиргаанд үзүүлэх уул уурхайн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг бууруулах, бэлчээрийн менежментийн чиглэлээр орон нутгийн захиргаа, малчдын санал, санаачлагыг дэмжин хамтран ажиллах, хамтран хөгжих зарчимаар сайн хөршийн харилцааг бий болгох, хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулна.

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

Мөн уламжлалт мал аж ахуй болон байгаль орчин, ан амьтан, биологийн олон янз байдлийн харилцан хамаарал, эко-системийн үйлчлэлийн хэрэгцээг хадгалах, тэнцвэржүүлэх чиглэл дээр бэлчээр, мал аж ахуй болон биологийн олон янз байдлын үндэсний мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд тус удирдлагын төлөвлөгөө нь доорх зорилтуудыг тавьсан:

- Компанийн үйл ажиллагаанаас бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар төрийн болон орон нутгийн гол оролцогч талуудтай хамтран ажиллах замаар орон нутагт бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Бэлчээр нутагтай харилцан хамаарал бүхий газар тариалан, усны нөөц, биологийн олон янз байдал зэрэг чиглэлүүдийн зөрчилдөөнд асуудлуудыг зохицуулахад дэмжлэг үзүүлэх ;
- Газар зохион байгуулат, бэлчээрийн менежментийн талаар улсын болон орон нутгийн засаг захиргааны бодлого, удирдамж зааварчилгааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд орсон газар нутагийн малчид бэлчээрийн усан хангамжын хэрэглээгээ булаг болон худгаас хангах боломжоо хэвээр хадгалахад дэмжлэг үзүүлэх;
- Малчдын амьжиргаанд шууд нөлөөлдөг бэлчээрийн менежмент болон малын эрүүл мэндийн менежментийн талаарх бодлого чиглэл, хэрэгжилт зэрэг холбогдох мэдээллийг малчдад шуурхай хүргэхэд дэмжлэг үзүүлэх;
- Малчин өрхөд нэмэлт орлогын эх үүсвэр бий болгох, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хамтын ажиллагаа, хоршоо хөгжүүлэх санал, санаачлагыг дэмжих;
- Нүүдэлчдийн соёл, Монголын бэлчээр ашиглах уламжлал, мал маллах арга ухаан, уламжлалыг хамгаалах санал санаачлагыг дэмжих;
- Байгал дэлхийгээс авах эко-системийн үйлчилгээний үнэ цэнэ, үйл ажиллагааг тогтвортой байлгах, ашиг шимийг хүртэгчид шаардлагатай үйлчлэлийг тогтвортой, үр ашигтай байлгахад анхаарч ажиллах .

1.3 Эхлэх хугацаа

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь 2017 оны 1-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

1.4 Хариуцлага ба удирдлага

ОТ-н Орон нутгийн харилцааны Ерөнхий менежер энэхүү Удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцна. Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хүсэлтийг уг албан тушаалтанд гаргах ба өөрчлөлтийн удирдлагын журамд зааснаар хянан үзэж, батална.

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Ерөнхий тойм

Монгол орны нийт газар нутгийн 80 орчим хувийг эзэлдэг бэлчээрийн хэв шинж бүхий газар нь мал аж ахуй эрхлэн амьдардаг нэг сая хүн буюу нийт хүн амын гуравны нэгний амьжиргааны шууд эх үүсвэр болдог.

Мал аж ахуй: Мал аж ахуйн салбар нь Монгол улсын эдийн засгийн нэг гол салбар ба Өмнөговь аймгийн нийт хүн амын талаас илүү хувь нь мал аж ахуйн салбарт ажиллаж, амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлж байна. Өмнөговь аймаг нь 2018 оны 4-р улирлын улсын тооллогоор малтай өрхийн тоо 7108 байснаас тэдгээрийн 5951 буюу 83% -ийг нь малчин өрхөөр тоолжээ. Тус онд нийт малын тоо 2,598,440 байсан. Үүнийг 2014 онтой харьцуулахад таван хошуу малын тоо төрөл бүр дээр нэмэгдсэн, тухайлбал тэмээ 152,280, 96,540адуу, үхэр 26,860, хонь 631,410, 1,691,340ямаа байна.

Бэлчээр нутаг: Өмнөговь аймгийн нийт газар нутгийн 61,3 хувь буюу 10,498,400 га талбайг хөдөө аж ахуйн газар эзэлдэг. Монгол улсын газрын нэгдмэл сангийн ангиллын дагуу бэлчээрийн газар нь хөдөө аж ахуйн газрын ангилалд хамаардаг бөгөөд . Өмнөговь аймагийн нийт хөдөө аж ахуйн газрын 10,137,200 га буюу 96,5 хувийг эзэлж байна.

Ан амьтан: Мөн түүнчлэн бэлчээрийн талбай нь төрөл бүрийн ургамал, сүүн тэжээлтэн, шувууны амьдрах орчин болдог тул бэлчээр нь биологийн олон янз байдалтай цогц, харилцан хамааралтай. ОТ-н нөлөөллийн талбайд дэлхийд болон Монголд ховордсон олон чухал төрөл зүйлүүд тархсан байдаг. Энэхүү жагсаатад дараах төрөл зүйлс багтах боловч үүгээр хязгаарлагдахгүй, хулан (*Equus hemionus*), хар сүүлт (*Gazella subgutturosa*), аргаль (*Ovis ammon*), янгир (*Ibex sibirica*), жороо тоодог (*Chlamydotis undulata*) г.м.

Энэхүү Удирдлагын төлөвлөгөөний баримт бичиг нь мал, амьтны бэлчээр ашиглалтыг онцгойлон тодорхойлсон ч Бэлчээрийн тогтвортой менежментийн асуудал нь өөрөө мал аж ахуй, биологийн төрөл зүйл хамгаалалт, усны менежментийн асуудлуудыг уялдаа холбоотойгоор авч үздэг бөгөөд үүн дээр Оюу Толгой ХХК-ний үйл ажиллагааны стандарт шаардлага, арга барил, хэрэгжилтийн арга замуудыг суулгаж өгсөн.

2.2 ОТ-н нөлөөллийн бүсэд орших бэлчээр, малчид

2018 оны 4-р улирлын улсын мал тооллогоор Ханбогд суманд мал маллан амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлдэг 386 малчин өрх байна. 2012 оноос хойш Ханбогд сумын малчин өрхийн тоо тогтвортой байгаа бол 2014 оноос таван хошуу малын (тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа) тоо өссөн. 2015 оны 4-р улирлын байдлаар нийт малын тоог авч үзвэл тэмээ 23375, адуу 7082, үхэр 3745, хонь 36434, ямаа 62377 болжээ. Эдгээр үзүүлэлтээс харахад Ханбогд сум нь улсын хэмжээнд тэмээний тоогоор тэргүүлж байна. Үүнээс гадна Ханбогд сум Өмнөговь аймгийн хэмжээнд үхэр сүргийн тоогоор тэргүүлдэг.

Хэдийгээр малын тоо толгой тогтвортой өсөж байгаа хэдий ч малын эм, бэлдмэлийн хүртээмж хомс, мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмж муугийн улмаас мал сүргийн эрүүл мэндийн асуудал орхигдох, уу, малын өвчлөл нэмэгдэх хандлага байсаар байна. Өмнөговь

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

аймгийн Хөдөө аж ахуйн газрын 2015 оны тайлангаас харахад мал аж ахуйн салбарт тулгараад байгаа нэг хүндрэл нь малын өвчлөл гэж тодорхойлсон байна

Бэлчээр нутгийн хувьд Ханбогд сум нь цөл, талын экосистемийн ургамлын онцлогийг агуулсан бөгөөд ургамлын бүрхэвч нь сийрэг намхан байдаг. Ийм экосистемийн бэлчээр нутгийн гарц нь хур борооноос ихээхэн шалтгаалдаг тул бэлчээрийн ашиглалтын байдал жил, улирлаар өөр өөр байдаг.

Байгаль орчин, цаг агаарын эдгээр хүчин зүйлээс гадна сүүлийн жилүүдэд ОТ болон бусад уул уурхайн компануудын дэд бүтцийн бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, үйл ажиллагаанаас үүдэлтэй бэлчээр, малчдын амьдралд үзүүлэх нөлөөлөл нэмэгдэж байна.

Үүнээс ОТ-н Бэлчээр, малчдын амьжиргаанд үзүүлж буй нөлөөллийг тоймлон дурдвал:

- Уурхайн лицензит талбайгаас малчин өрхийг газар зүйн байршлын хувьд нүүлгэн шилжүүлэх, мөн уурхайн лицензит талбайн төвөөс 10 км-ын радиусд орших суух хориотой заалт бүхий бүсээс малчдын өвөлжөөг нүүлгэн шилжүүлсэн. 2015 оны байдлаар ойролцоогоор 10,400 га газрыг ОТ уурхай болон холбогдох үйл ажиллагаанд ашиглаж байна;
- Онгоц буудал байгуулахад зориулан газар чөлөөлөн тухайн талбайд нэвтрэхийг бүрэн хориглосны улмаас ашиглах бэлчээр хязгаарлагдмал болж болон нөлөөлөлд өртсөн малчдын эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт;
- Шугаман дэд бүтэц барьж байгуулах үйл ажиллагаа ажиллуулсны улмаас бэлчээрийн хуваагдал үүсэх (ОТ – Гашуун сухайтын зам, боловсруулаагүй усан хангамжийн шугам хоолой г.м);
- Уст цэг ашиглах боломжыг хязгаарлаж, усан хангамж багасах, уст цэгийн тоо буурах
- Бэлчээрийн зориулалт бүхий газрыг өөр ашиглалтад шилжүүлэх, Ханбогд суманд ирэх шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн зэргээс үүдэн бэлчээрийн талбайн хэмжээ багасч, чанар доройтсоноор үүдсэн газрын төлөө өрсөлдөөнийг буй болгох, Уурхайн үйл ажиллагаа болон тээвэрлэлтээс үүсэх тоосжилтын улмаас мал сүргийн эрүүл мэнд муудаж, бэлчээрийн чанар алдагдаж байгаа гэсэн малчдын ойлголт нэмэгдэх. Мөн залуучууд уурхайд ажиллах сонирхолтой болсны улмаас нүүдлийн мал аж ахуй эрхлэх залгамж халаа алдагдах.

Нутгийн малчид нь Оюу Толгой компанийн орон нутаг дахь гол оролцогч тал юм. Тэд сүүлийн жилүүдэд байгаль орчин, нийгмийн олон төрлийн хүчин зүйлээс үүдэлтэй хам нөлөөлөлд учирч байна. ОТ нь нутгийн малчдын амьжиргаа болон, тэдний амьдрах орчинд тодорхой нэмжээгээр нөлөө үзүүлж буйгаа хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэхүү нөлөөллийг багасгахад анхаарал хандуулан ажиллаж байна.

2.3 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд одоогийн явуулж буй үйл ажиллагаа, гүйцэтгэгчийн үйл ажиллагаа зэрэг Гүний уурхайн бүтээн байгуулалттай холбоотой ОТ-н зүгээс орон нутгийн

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих санал санаачлага, амлалт, үүрэг хариуцлагыг тусгасан болно. Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөөнд дэд бүтцийн өргөтгөлийн ажил, төслийн үйл ажиллагаанаас үлдэх нөлөөллийг бууруулах ажил, , барилга, дэд бүтцийн ажилтай холбоотой бэлчээр, амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг бууруулах, удирдан зохицуулах арга хэмжээ багтана.

Энэхүү удирдлагын төлөвлөгөөг ОТ-н бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих үүрэг амлалтын хэрэгжилтийг ОУСК-ийн 5 болон 6 (ГС 5, 6) –р гүйцэтгэлийн стандартын 2006 оны хувилбар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны 5 болон 6-р (PR5 & 6) гүйцэтгэлийн стандартын дагуу хэрэгжүүлэх ажилд чиглэл өгөх зорилгоор боловсруулсан.

Энэхүү төлөвлөгөө нь газарзүйн хамрах хүрээний хувьд Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдад төвлөрөх боловч нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ нь биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтээр ОТ-н шууд нөлөөнд өртсөн малчид болон Ханбогд сумын шууд бусад малчин айл өрхүүдэд чиглэнэ.

2.4 Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхацсан байдал

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөний (БОНМТ) хамрах хүрээнд (ОТ-10-PLN-0003-Е) зааснаар, ОТ-н үйл ажиллагаа, Гүний уурхайн төсөлд зориулан боловсруулсан Үйл ажиллагааны менежментийн нэгдсэн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болно. Тус удирдлагын төлөвлөгөө нь Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд шаардагдах шууд үүрэг амлалт юм.

Удирдлагын төлөвлөгөө нь бусад хэд хэдэн удирдлагын төлөвлөгөөтэй харилцан уялдаа холбоотой. Үүнд:

- Нүүлгэн шилжүүлэлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө (ОТ-10-PLN-0006), мал аж ахуй эрхэлдэг малчин айл өрхөд үзүүлэх нөлөөллийг бууруулах, малчдын амьжиргааг сайжруулахтай холбоотой;
- Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө (ОТ-10-PLN-0008), тодруулбал хамтын ажиллагааны арга хэрэгсэл болон төрөл бүрийн оролцогч талуудтай хамтран ажиллах арга замтай холбоотой;
- Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0005), бэлчээрт шууд сөрөг нөлөө үзүүлэх газар хөндөлтийг бууруулахтай холбоотой;
- Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-1001), биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахтай холбоотой;
- Дүйцүүлэн хамгааллын удирдлагын төлөвлөгөө (удахгүй гарна), биологийн олон янз байдалд үзүүлэх үлдэгдэл нөлөөллөөс дүйцүүлэн хамгаалах, эерэг нөлөө ахиу үзүүлэх төслийн үүрэг амлалтад хүрэхтэй холбоотой;

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

- Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е11-PLN-0001), бэлчээрийн менежменттэй шууд холбоотой сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой;
- Шилжилт хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-PLN-0007), ОТ-н ажилчид болон бэлчээрт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй Ханбогд сумын ойр орчимд ажил хайн нүүж ирэгсдийн сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой.

2.5. Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөртэй давхацсан байдал

ОТ төсөлтэй хамгийн ойрхон орших сумдын нутгийн иргэд байгаль орчны болзошгүй шууд болон шууд бус нөлөөллийн талаар олон асуудлыг тодорхойлон тогтоосон. Эдгээр асуудалд дараах зүйлсийг онцгойлон авч үзсэн боловч үүгээр хязгаарлагдахгүй юм. Үүнд: гүний усны хомсдол, бохирдол, горхи, булаг шандны бохирдол, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, бохирдуулагч бодисын бэлчээрт үзүүлэх нөлөө, малчдын мал сүрэг, зэрлэг ан амьтан үргэж дайжих, тээврийн хэрэгсэл бэлчээрийг эвдлэх, замын хөдөлгөөнөөс үүсэх тоос. г.м

Байгаль орчны өөрчлөлт, түүнд үзүүлэх нөлөөллийг хянах, шинжилгээний үр дүнг хэлцэхэд нутгийн иргэдийг оролцуулсан зохион байгуулалттай механизмыг бий болгосноор байгаль орчинд үзүүлсэн бодит нөлөөлөл болон түүнийг хянах, зохицуулах чиглэлээр ОТ-н зүгээс хийж буй ажлын талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ. Энэ нь цаг хугацааны явцад компани болон нутгийн иргэдийн хоорондын итгэлцлийг бий болгоход тусалж, асуудлыг хамтаар шийдэх боломж олгоно. Энэхүү зорилтыг бодолцон, ОТ-той холбоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт олон нийтийг оролцуулах, оролцоог хангах үүднээс Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөр (ХОБОМХ) –ийг боловсруулсан. Дараах үр дүнд хүрнэ гэж тооцоолж байна:

- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт олон нийт идэвхтэй оролцох;
- Байгаль орчны асуудлын талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх;
- Ашигласан хяналт шинжилгээний арга барил болон олж авсан мэдээллийн талаар олон нийт итгэл үнэмшилтэй болно;
- Олон нийтийн санааг зовоож буй асуудалд ОТ-с хариу өгөх боломж нэмэгдэнэ;
- ОТ-н байгаль орчны нөлөөллийн удирдлагын арга барилд олон нийт хувь нэмэр оруулж, дэмжлэг үзүүлнэ.

ХОБОМХ –ний хөтөлбөрийн тоймыг хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийн тойм

Сэдэвчилсэн салбар/чиглэл	Оролцогч	Байршил	Тодорхойлолт	Давтамж	Мэдээлэл
Усны түвшин (PWLM)	78 малчин	Ханбогд	Малчдын худаг	Сард удаа 10	Усны түвшин, усалсан амьтны тоо,

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

Амьтны аймаг (PFM)	20 малчин	Ханбогд	Сүүн тэжээлтэн, шувуу бусад бичил биетэн	3-с 11-р сарын хооронд сард 1 удаа	Шугаман болон цэгэн огтлолцолын ажиглалтын арга, зургаар баримтжуулах
Ургамалжилт (PVM)	12 малчин	Ханбогд	Ундай голын хайлаас модны тоо, чанарын мониторинг	3-с 11-р сарын хооронд сард 1 удаа	Тухайн хугацаанд дахь ногоон хэсгүүдэд фото мониторинг хийх
Тоосжилт/тоос (PDM)	Шаардлагын дагуу	Ханбогд	ОТ-н тоосны хяналтын 17 станц	Шаардлагын дагуу	PM 2.5; PM 10; TSP (нийт жинлэгдэгч бодис)
Олон нийтийн байгаль орчны мэдлэг мэдээлэл	Сурагчид болон Эко клуб	Ханбогд	Байгаль орчны олон Говийн бүсийн ховор амьтан, экосистемийн 12 загварчлал	9 сараас 12 сар хүртэл долоо хоног бүр	Сургалтын 12 модул, Байгаль орчны өдрийг тэмдэглэх

Гурван талт зөвлөлийн Малчдын гомдол барагдуулах гэрээний хүрээнд Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийг (ХОБОМХ) шинэчлэн хэрэгжүүлсэн. 2017 онд Ханбогд сумын малчид хамтран Мөнх ногоон Галба ТББ –ийг 93 гишүүнтэйгээр байгуулсан. Энэхүү ТББ нь орон тооны зургаан ажилтантай ба ХОБОМХ-ийг хэрэгжүүлж, мониторингийн тайланг нэгтгэн дүгнэж байна. ОТ компани нь Мөнх ногоон Галба ТББ–тай хамтран ажиллах гэрээний дагуу жил тутмын санхүүжилт олгож байна. Байгаль орчны мониторингийг мэргэжлийн түвшинд гүйцэтгэхийн тулд ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх ажил тэргүүлэх зорилт болоод байна. 2019 оны хоёрдугаар улирлын байдлаар Ханбогд сумын хэмжээнд 98 малчин байгаль орчны мониторингийн хөтөлбөрт оролцож, мониторингийн хэмжилт хийж байна.

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

3 АЛБАН ТУШААЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

3.1 Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх гол үүрэг хариуцлага

Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол ажилтнууд, тэдний үүрэг хариуцлагыг доор оруулав.

Хүснэгт 2: Гол албан тушаалтан, үүрэг хариуцлага

Албан тушаал	Үүрэг хариуцлага
Орон нутгийн харилцааны Ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> Төлөвлөгөөний Хэрэгжилтийг хангах үүднээс шаардлагатай нөөцөөр хангах зэргээр энэхүү Удирдлагын төлөвлөгөөний ерөнхий хэрэгжилтийг хариуцана. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Өмнөговь аймгийн Засаг, захиргаатай хамтран ажиллах.
Байгаль орчин, биологийн олон янз байдлын менежер	<ul style="list-style-type: none"> Байгаль орчин, биологийн олон янз байдлын багийн гишүүдийн оролцогч талуудтай усны нөөц, газар ашиглалт, газрын нөхөн сэргээлт, бэлчээрийн чанарын хяналт, Үйл ажиллагааны удирдлагын төлөвлөгөөний оролцогч талуудтай холбоотой харилцаа, хамтын ажиллагааг удирдан зохицуулах үүрэгтэй.
Орон нутгийн дэмжлэг болон түншлэл хариуцсан хэлтсийн менежер (ОНДТ)	<ul style="list-style-type: none"> ОТ-н баг, хамт олонд энэхүү удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, сайжруулах талаар шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох Шаардлагын дагуу энэхүү төлөвлөгөөний үр дүнтэй холбоотой зөвлөгөө авахад мэргэжилийн байгууллагуудтай хамтарч ажиллах Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ОТ-н холбогдох баг, хэлтэсүүдтэй хамтран ажиллах Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Сумдын засаг, захиргаатай хамтран ажиллах
Хууль, дүрмийн хэрэгжилт, засаглал хариуцсан менежер	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагааны удирдлагын төлөвлөгөөний хяналт, үүрэг амлалтын хяналт шинжилгээ, үнэлгээ болон тайлагналыг зохицуулах
Экосистемийн үйлчилгээний хэсэг (ЭҮАХ) ажлын	<ul style="list-style-type: none"> Холбогдох асуудлыг хэлэлцэх, экосистемийн үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг санал болгох байдлаар үйл ажиллагааны удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар зөвлөлдөх. Үр дүнг үнэлж дүгнэн, нэн чухал экосистемийн үйлчилгээтэй холбоотой ҮАҮТ-г хэрэгжүүлэх төлөвлөгөөг санал болгох. Экосистемийн үйлчилгээний хяналт, үнэлгээний хамрах хүрээний хэрэгжилтийг баталгаажуулах
Орон нутгийн харилцааны мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> Энэхүү Удирдлагын төлөвлөгөө болон Орон нутгийн хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих стратегийн хэрэгжилтийг хариуцана ОТ болон, малчдын амьжиргааг дэмжих төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагаанд малчдын бүлэг болон хоршоодын хамтын ажиллагааг зохицуулах

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

Орон нутгийн харилцааны ажилтан	<ul style="list-style-type: none"> • Малчдын бизнес, эдийн засгийн хөгжил, орон нутгийн ажилчдын сургалт, боловсролын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх • ОТ болон, бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргаа, малчид, ТББ-уудтай хамтран ажиллах
---------------------------------	--

3.2 Удирдлагын төлөвлөгөөний удирдлага

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих үйл ажиллагааны удирдлагын төлөвлөгөөний үндсэн зорилго нь бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүд болон энэ чиглэлээр орон нутгийн Засаг захиргаа, малчдын зүгээс гаргасан санал санаачлагад дэмжлэг үзүүлэх ОТ-н гүйцэтгэх үүргийг тодорхойлоход юм.

Бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх аливаа харилцаанд Монгол улсын төр, төрийн нэгж нь Монгол улсын Газрын тухай хуульд заасан үндсэн эрх, үүрэгийн дагуу тэргүүлэгчийн үүрэгтэй оролцоно.

Удирдлагын төлөвлөгөө нь ажлын дөрвөн тулгуураас бүрдэнэ:

- 1) Бэлчээрийн менежмент;
- 2) Усны нөөц;
- 3) Малчны амьжиргааг сайжруулах;
- 4) Биологийн олон янз байдал болон хамгаалал;

Дөрвөн тулгуурын дагуу удирдлагын RACI/Ажил үүргийн хуваарилалтын матрицыг Хүснэгт 3-д харуулав.

Хүснэгт 3: Ажил үүргийн диаграм

	Бэлчээрийн менежмент	Усны нөөц	Амьжиргааг сайжруулах	Биологийн олон янз байдлыг хамгаалах
Орон нутгийн харилцааны Ерөнхий менежер	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Мэдээлэл авах
Экосистемийн үйлчилгээний ажлын хэсэг	Зөвлөлдөх	Техникийн баталгаа, хариуцах хүн	Зөвлөлдөх	Удирдах, батлах
Орон нутгийн харилцааны баг	Техникийн баталгаа, хариуцах хүн	Зөвлөлдөх	Техникийн баталгаа, хариуцах хүн	Зөвлөлдөх

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

Биологийн олон янз байдлын баг	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Мэдээлэл авсан	Техникийн баталгаа, хариуцах хүн
Усны баг	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Мэдээлэл авах	Мэдээлэл авах
Биологийн олон янз байдлын зөвлөх	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Мэдээлэл авах	Зөвлөлдөх
Өмнөговь аймгийн захиргаа	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Зөвлөлдөх
Ханбогд сумын захиргаа	Удирдах, батлах	Удирдах, батлах	Удирдах, батлах	Зөвлөлдөх
Говийн оюу ХДС	Зөвлөлдөх, санхүүжилт олгох	Зөвлөлдөх, санхүүжилт олгох	Зөвлөлдөх, санхүүжилт олгох	Зөвлөлдөх, санхүүжилт олгох
Орон нутгийн ТББ, ГТЗ	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Мэдээлэл авах
Малчдын хоршоо	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Мэдээлэл авах
Малчид	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Зөвлөлдөх

3.3 Экосистемийн үйлчилгээний ажлын хэсэг

Экосистемийн үйлчилгээ гэдэг нь (ЭҮ) ерөнхийдөө хүний экосистемээс хүртдэг үр ашгийг хэлнэ. TBC & FFI (2012) –ын Нэн чухал амьдрах орчны үнэлгээний тайлангийн дагуу ОТ төсөлд нэн чухал дөрвөн ЭҮ – г тодорхойлсон. Үүнд, бэлчээр, биомассын эрчим хүчний түүхий эдүүд, цэвэр ус, усны зохицуулалт багтана. ОТ компани ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт, ЕСБХБ –ны гүйцэтгэлийн шаардлага, Рио Тинтогийн дотоод үүрэг амлалт зэрэг олон улсын холбогдох стандартуудыг төсөлд ашиглах үүрэг хүлээсэн. ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 6 болон ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 6-ын дагуу ОТ-д дараах шаардлага тавигддаг:

- ЭҮ-нд үзүүлэх нөлөөллийг бууруулах, нөлөөнд өртсөн орон нутгийн иргэдэд тэдгээр ЭҮ-ний үнэ цэнэ, гүйцэтгэлийг тогтвортой байлгахад чиглэсэн, нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх; and
- Хугацааны туршид үйл ажиллагаа болон төсөлд нэн чухал ЭҮ-г тогтвортой байлгах үүднээс нөлөөллийг бууруулах.

Бэлчээрийн нөөц (ө/х мал сүрэг адгуулахад чанартай ургамалан бүрхэвч) болон цэвэр усан хангамж нь (малчдын ашиглах боломжтой усны нөөц) нь Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсэг нь юм.

Экосистемийн үйлчилгээний ажлыг хэсэг (ЭСАХ) нь Оюу Толгой ХХК-ийн дотоод хяналтын ажлын хэсэг бөгөөд Орон нутаг, байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлж буй олон тооны төсөл хөтөлбөр, үүрэг амлалт, тулгамдсан асуудлуудаас үүдэн гарах харилцааг зохицуулах, мэдээлэх, шийдвэр гаргах (шаардлагатай нөхцөлд), чиглүүлэх, хянах, дүгнэх зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулна. Ажлын хэсэгт Байгаль орчин,

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

орон нутгийн хэлтсийн ахлах удирдлагын багийн гишүүд багтдаг. ЭСАХ шаардлагатай бол ОТ-н биологийн олон янз байдлын түншлэгчийн тусламж дэмжлэгийг авч болох ба тэд экосистемийн үйлчилгээ, зэрлэг ан амьтан, малчдын сонирхлын давхардал, зөрчлийг тогтвортой байдлаар тэнцвэржүүлэх чиглэлээр хамгийн шилдэг, сүүлийн үед гарч ирж буй туршлагын талаар зөвлөгөө, санал зөвлөмж өгнө.

ЭСАХ нь нэн чухал Экосистемийн үйлчилгээний дөрвөн үзүүлэлтэд чиглэсэн Экосистемийн үйлчилгээний хяналт, үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана, үүнд: **хангамж** (ө/х одоогийн өгч буй үр өгөөж), оролцогч талуудын хүртэх **үр өгөөж**, Экосистемийн үйлчилгээний хангамжид үзүүлэх **дарамт**, тэдгээр дарамтад ОТ-с авах **хариу арга хэмжээ**. Эдгээр дөрвөн үзүүлэлтэд үнэлэлт дүгнэлт хийснээр Гүйцэтгэлийн стандарт 6-ийн дагуу ОТ-д тавьсан шаардлага болох нөлөөлөлд өртсөн ЭҮ-ний ашиг шим хүртэгчдийн хувьд Экосистемийн үйлчилгээний үйл ажиллагаа, үнэ цэнийг тогтвортой болгоно.

Экосистемийн үйлчилгээний хяналт, үнэлгээний төлөвлөгөөнд бэлчээр (P1 -с P10), биомассын эрчим хүчний түүхий эдүүд (B1 -с B8), цэвэр ус (F1 -с F12) болон усны зохицуулалт (W1 -с W7)-ын тусгай үзүүлэлтүүдийг тусгасан. Үзүүлэлтийг хянах арга барил, давтамж, газарзүйн хамрах/цар хүрээ, хариуцах тал болон зохих менежментийн хяналтын арга хэмжээ хэрэгжүүлэх босго үзүүлэлтийн талаар дэлгэрэнгүйг ЭҮХҮТ-нд тоймлон оруулсан.

3.4 Гол уялдаа холбоо

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтэд оролцох гол хүмүүс (Удирдлагын төлөвлөгөөний элементүүдийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн албан тушаалтнууд):

- Орон нутаг, нийгмийн харилцааны хэлтэс,
- ЭМААБОАБ-ын хэлтэс;
- Хангамжийн хэлтэс
- Үйл ажиллагаа, дэд бүтцийн баг;
- Гадаад харилцаа, олон нийттэй харилцах хэлтэс.

Гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнтэй холбоотойгоор орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах, тэдний хүлээлтийг удирдан зохицуулах хэрэгцээ шаардлагаас үзвэл дараах оролцогч талуудыг энэхүү удирдлагын төлөвлөгөөний гадаад гол холбоотон/харилцагч гэж тодорхойлсон:

Орон нутгийн засаг захиргаа:

Ханбогд сумын Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн хөтөлбөр (МААТХХ):

- МААТХХ нь Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт технологитой хослуулан уул уурхайн бүс нутагт жишиг байдлаар хөгжүүлэн малчид, иргэдийн мал аж ахуйн салбараас олох орлогыг нэмэгдүүлж, мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх зорилготой.

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

- Энэхүү хөтөлбөр нь Ханбогд сумын малчид, нутгийн иргэд, төр захиргааны ажилтнуудын санал, зөвлөмж болон бэлчээр, мал аж ахуйн салбарт өмнө хийгдсэн судалгаа шинжилгээний үр дүнд нэгэтгэн боловсруулагдсан ба Ханбогд сумын малчдын зөвлөгөөн, Гурван талт зөвлөлөл(ГТЗ)-д хэлэлцүүлэгдэн Ханбогд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 15/03 тогтоолоор баталагдсан
- МААТХХ –ийн хэрэгжилтийг сумын хэмжээнд зохицуулах үүрэг бүхий 11-ээс цөөнгүй гишүүнтэй хороо ажиллана. Хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг сумын ИТХ батална. Хороог сумын Засаг дарга ахлах бөгөөд нарийн бичгийн дарга нь ЗДТГ-ын Мал эмнэлэг-үржлийн тасгийн дарга байна. Бусад бүрэлдэхүүнд багийн Засаг дарга, малчид болон холбогдох бусад оролцогч талуудын төлөөлөл орсон байна. ОТ нь хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Орон нутгийн иргэд, сонирхлын бүлэг:

Ханбогд сумын Гурван талт зөвлөл (ГТЗ):

- ГТЗ нь Ханбогд сумын захиргаа, малчдын төлөөлөл болон ОТ-с бүрдсэн зөвлөл юм. Нутгийн хэсэг малчдын Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газар - т ирүүлсэн хоёр өргөдлийг шийдвэрлэх үүднээс ГТЗ-ийг байгуулсан. ГТЗ нь малчид, бэлчээр, ус болон холбогдох бусад асуудал, гомдол, санал, санаачлага, зөвлөмж, гомдолтой холбоотой зөвлөмжийн тухай мэдээллийг авч үзэх, хэлэлцэх, шийдвэрлэх, солилцох, санал зөвлөмж гаргах, хэрэгжүүлж, холбогдох дээд түвшинд мэдээлэх үүрэгтэй.
- ГТЗ нь гомдол саналыг шийдвэрлэх чиглэлээр ажиллахын зэрэгцээХамтын ажиллагааны гэрээний хүрээнд Ажлын хэсгээр ажиллаж, Харилцааны хороонд мал аж ахуйг хөгжүүлэх санал санаачлагын талаар завлөж ажиллахыг зөвшөөрсөн. Ханбогд сумын Засаг даргаас албан ёсоор хүсэлт гаргасны дагуу ГТЗ нь 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн Нөхөн олговрын хамтарсан ажлын хэсгээр ажиллахыг зөвшөөрсөн.

4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД

Холбогдох стандартуудыг бүх Үйл ажиллагаа, төслийн үйл ажиллагаанд (“Стандарт”) дагаж мөрдөх ёстой. Стандартууд нь дараахаас бүрдэнэ:

- Монгол улсын холбогдох хууль тогтоомж
- Монгол улсынхолбогдох стандартууд;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ) – ний шаардлагууд;
- Монгол улсынЗасгийн газрын өмнө хүлээсэн үүрэг амлалт, шаардлагууд;
- Зээлдүүлэгчийн холбогдох стандартууд;

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

- Рио Тинтогийн холбогдох стандартууд.

4.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж

- Монгол улсынхуулиуд
 - Үндсэн хууль (1992);
 - Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003);
 - Иргэний хууль (2002).
 - Газрын тухай хууль, 2002 (2015 онд өөрчлөлт оруулсан);
 - Байгалийн ургамлын тухай хууль, 1995 (2010 онд өөрчлөлт оруулсан);
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012;
 - Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 (2012 онд өөрчлөлт оруулсан);
 - Монгол улсын усны тухай хууль, 2012.
 - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хууль, 2012.
- Монгол улсынхолбогдох стандартууд

Монгол улсын стандартчлал, хэмжилзүйн газар Монгол улсын стандартуудыг боловсруулсан. Эдгээр стандартад ургамалжуулах зэрэг газрын нөхөн сэргээлт, уурхайн нөхөн сэргээлттэй холбоотой биологийн олон янз байдлын асуудлыг тусгасан стандартууд багтана, үүнд:

- MNS 5914:2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт.
- MNS 5915:2008. Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
- MNS 900:2010. Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт, (2010 онд нэмэлт өөрчлөлт оруулсан).

4.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ) – ний шаардлагууд

БОНБНҮ-нд хавсралтаар оруулсан Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон Байгаль орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөнд заасан газар хөндөлтийг хянах, нөхөн сэргээлтийн менежментийн шаардлагуудыг Бэлчээр, амьжиргааг сайжруулах удирдлагын төлөвлөгөөнд нэгтгэн оруулсан. Газар хөндөх, нөхөн сэргээхтэй холбоотой хуулиар хүлээсэн ОТ-н үүргийг МУ-ын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу бэлтгэн гаргасан БОНБНҮ-ний тайланд оруулсан.

4.3 ОТ болон Рио Тинтогийн холбогдох стандартууд

- ОТ- Өмнөговийн хамтын ажиллагааны гэрээ (ХАГ)**

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

Оюу толгой ХХК-н Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл болох Оюу толго - Өмнөговь аймгийн Хамтын ажиллагааны гэрээ (ХАГ) нь 2011 оны 4-р сард талуудын өргөн хүрээг хамарсан зорилтуудыг тодорхойлсон Харилцан Ойлголцлын санамж бичиг (ХОСБ)–т Өмнөговь аймаг, Ханбогд сум болон Оюу толгой ХХК гарын үсэг зурснаар эхэлсэн

Үүний дараа нь 2012 оны 9-р сард орон нутгийн түвшинд гэрээ байгуулах шилдэг туршлагад нийцүүлэн хэлэлцээр хийх зарчим, гол журмуудыг тусгасан Үйл явцын гэрээ (ҮЯГ) – г байгуулсан.

ҮЯГ-ний дагуу бодитой хамтын ажиллагаа, хэлэлцээр хийсний дагуу 2015 оны 4-р сарын 22-нд Өмнөговь аймаг, Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдын засаг дарга нар болон Оюу толгой ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал нар бүрэн ХАГ-нд гарын үсэг зурсан. Бусад хэлэлцэн тохиролцсон тодорхойлолтуудын хамт ХАГ-нд Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдыг ОТ-н Түншлэгч сумд гэж тодорхойлсон. Энэхүү Түншлэгч сумд гэсэн тодорхойлолт нь МУ-ын БОНБНУ болон Зээлдүүлэгчийн БОННБУ зэрэг гуравдагч талын баримт бичгүүдэд “Шууд нөлөөллийн талбай”, “Шууд бус нөлөөллийн талбай” гэсэн тодорхойлолтуудыг орлох юм.

ХАГ-нд харилцан хүлээх үүрэг болон Түншлэгч сумдыг тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн урт хугацааны үүрэг амлалтын зарчмуудын хүрээнд ОТ, Өмнөговь аймаг болон Түншлэгч сумд хэрхэн хамтарч ажиллахыг заасан. ХАГ-г хэлэлцэх явцад доорх сэдвүүдийг Түншлэгч сумдын тулгамдаж буй асуудал хэмээн тодорхойлж, хэлэлцэн тохиролцож, эцэслэн боловсруулсан ХАГ-нд Хавсралтаар оруулсан хамтарсан удирдлагын харилцан тохиролцсон протоколын хамт цогцоор нь авч үзсэн:

- Усны менежмент – Хавсралт 4
- Байгаль орчны хяналт шинижлгээ, хамгаалалт – Хавсралт 5
- Уламжлалт мал аж ахуй ба бэлчээрийн менежмент – Хавсралт 6
- Үндэсний түүх, соёл, аялал жуулчлал – Хавсралт 7
- Нийгмийн суурь үйлчилгээ (эрүүл мэнд, соёл, боловсрол, мэргэжлийн сургалт ба хөдөлмөр эрхлэлт) – Хавсралт 8
- Орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, тэдгээрээс бараа, үйлчилгээ худалдан авах – Хавсралт 9
- Дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төслүүд – Хавсралт 10

Хавсралт 6-д уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежментийн талаар талуудын хүлээсэн үүргийг тодорхойлсон:

- (а) Талууд уламжлалт мал аж ахуй, нүүдэлчдийн бэлчээр ашиглах уламжлалыг хадгалан хамгаалах, хөгжүүлэх талаар дэмжлэг үзүүлэх үүднээс өөр хоорондоо болон бусад холбогдох талуудтай хамтран ажиллахыг зөвшөөрч байгаа ба Талуудын хэрэгжүүлж буй дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн аливаа бодлогууд нь Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдын бодлоготой нийцсэн байна. Өмнөговь аймгийн ба Түншлэгч сумдын мал эмнэлэг, үржлийн асуудал эрхэлсэн газрууд буюу

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

нэгжүүд болон мал аж ахуйтай холбоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа хоршоод нь тухайн дэмжлэг үзүүлэх бодлогыг тодорхойлоход голлох үүрэгтэй оролцоно.

- (b) Дээрх бодлогуудад дэмжлэг үзүүлэх гэдэгт уламжлалт мал аж ахуй, нүүдэлчдийн бэлчээр ашиглах уламжлалыг хадгалан хамгаалах, хөгжүүлэх болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд (үүнд шинэ технологи нэвтрүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хөгжүүлэх болон бэлчээрийн менежментийг сайжруулах зэргийг оруулан) чиглэсэн холбогдох мэдээлэл, судалгаа болон мэдлэг зэргийг хамааруулж болно.
- (c) Талууд тогтвортой үйл ажиллагаа бүхий малчдын хоршоодыг үүсгэн байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг зөвшөөрч байна.
- (d) Талууд Түншлэгч сумдын бэлчээрийн усан хангамж дутагдалтай байгаа газарт бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, мал услах цэгүүдийг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлэх үүднээс орон нутгийн удирдлага болон бусад холбогдох талуудтай хамтран ажиллахыг зөвшөөрч байна.
- (e) Талууд Өмнөговь аймгийн холбогдох эрх бүхий байгууллагууд, Түншлэгч сумд болон гуравдагч талуудын оролцоотойгоор бэлчээрийн газрын үнэлгээг хийхэд дэмжлэг үзүүлэхэд хамтран ажиллахыг зөвшөөрч байна.
- (f) ОТ ХХК нь Хамтран ажиллах орон нутгийн хөндөгдсөн газрыг (үүнд Гэрээт талбай доторх газар хамаарахгүй) ОТ Төсөлд цаашид ашиглахгүй болсны дараа нүүдлийн малчид болон бэлчээрийн мал ашиглах, нэвтрэх боломжийг бий болгох зорилгоор боломжтой арга хэмжээ авахыг зорино.
- (g) Харилцан тохиролцсон протоколын дагуу ОТ ХХК нь мал сүргийг Гэрээт талбайд бэлчээрлэх боломжоор хангах бөгөөд энэхүү боломж нь тогтоосон хугацаанд бэлчээрлэх боломжтой байх ба түүний үргэлжлэх хугацаа, тодорхой байршил болон ОТ Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдал болон аюулгүй ажиллагаа, малчид, мал сүргийн аюулгүй байдалыг хангах асуудлуудыг тодорхой журмаар тодорхойлно.
- (h) Талууд нөлөөлөлд өртсөн малчин өрхөд зориулсан малчдын амьжиргааг сайжруулах хөтөлбөрт багтах тодорхой саналуудыг боловсруулах ба Харилцааны хороогоор дамжуулан тэдгээрийг хэрхэн боловсронгуй болгох тухай санал хүсэлтийг хүлээн авч, мөн түүнийг хэрэгжүүлэхэд Түншлэгч сумдаас дэмжлэг авна.
- (i) Талууд нөлөөлөлд өртсөн малчин өрхөд зориулсан шинэ төрлийн орлогын эх үүсвэр бий болгох төслүүдэд тодорхой саналууд боловсруулах ба Харилцааны Хороогоор дамжуулан тэдгээрийг хэрхэн боловсронгуй болгох тухай санал хүсэлтийг хүлээн авч, мөн түүнийг хэрэгжүүлэхэд Түншлэгч сумдаас дэмжлэг авна.

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

Гэрээний хүрээнд Өмнөговь аймагт хэрэгжүүлэх орон нутгийн төсөл хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Оюу толгой болон Орон нутгаас хамтран байгуулагдсанбие даасан байгууллага болох Говийн Оюу хөгжлийг дэмжих санг жил бүр 5 сая төгрөгөөр санхүүжүүлнэ

b. Рио Тинтогийн холбогдох стандартууд

Рио Тинто компани нийгмийн хариуцлагын өндөр шаардлага бүхий стандарт мөрдөж ажилладаг бөгөөд бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог, компанийн эрхэмлэх үнэт зүйлсийн тунхаглал нь “Бидний ажлын арга барил” хэмээх баримт бичигт тусгагдсан байдаг. Энэхүү баримт бичиг нь монгол, англи хэлээр ОТ-н цахим хуудсанд тавигдсан болно.

Рио Тинто компани нь Олон нийт болон нийгмийн асуудлын менежментийн цогц тогтолцоотой бөгөөд түүнийгээ Рио Тинтогийн удирддаг бизнесийн хувьд ОТ-д ч мөн хэрэгжүүлдэг. Рио Тинтогийн “Орон нутгийн стандарт” –ыг 2015 онд шинэчлэн боловсруулсан бөгөөд Рио Тинто компани нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдтэй ажиллан, мэдээлэл цуглуулж, түгээж нийгмийн нөлөөллийг удирдах төлөвлөгөө болон хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байдаг. Стандартын тусгай элементүүд нь ОТ-д үүсэж болох хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг удирдахад чиглэгдсэн байдаг. Үүнд:

- Орон нутаг, нийгмийн гүйцэтгэлийн төлөвлөгөө (Оюу Толгойн үйл ажиллагааны хүрээнд хийгдэж буй орон нутагтай холбоотой бүх ажлууд);
- Орон нутгийн нийгмийн суурь үнэлгээ;
- Харилцан зөвшилцөж, ойлголцсон зөвлөлдөх журам;
- Бизнесийн нийгмийн нөлөөллийг ойлгох, удирдан зохицуулах, хянах;
- Орон нутгийн асуудлаарх санал санаачлага, туслалцаа;
- Соёлын өвийн менежмент;
- Гомдол, маргаан, зарга шийдвэрлэх журам;
- Хүний эрхийг хамгаалах;
- Орон нутагтай хийсэн гэрээнүүд.

Рио Тинтогийн орон нутгийн асуудлаар хэрэгжүүлдэг стандартуудын талаарх мэдээллийг Рио Тинтогийн цахим хуудаснаас¹ үзэх боломжтой.

4.4 Холбогдох олон улсын стандарт, удирдамжууд

Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын бодлого болон гүйцэтгэлийн стандартад (2006) нийгэм, байгаль орчны нөлөөлөл түүний дотор газар, бэлчээр, амьжиргаагаар холбоотой нөлөөллийг удирдан зохицуулах өргөн

¹ www.riotinto.com/documents/Communities_standard.pdf

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

хүрээний санал зөвлөмжийг тусгасан. Энэхүү төлөвлөгөөнд холбогдох гүйцэтгэлийн гол стандартууд нь:

- Гүйцэтгэлийн стандарт 1: Нийгэм, байгаль орчны үнэлгээ ба менежментийн систем;
- Гүйцэтгэлийн стандарт 4: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал;
- Гүйцэтгэлийн стандарт 5: Газар чөлөөлөлт ба албадан нүүлгэн шилжүүлэлт.
- Гүйцэтгэлийн стандарт 6: Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой байдлын менежмент

ОТ нь ОТ төслийг хэрэгжүүлэхдээ ОУСК-ийн 1, 4, 5 болон 6 –р Гүйцэтгэлийн стандартуудын шаардлагыг мөрдөж ажиллана.

Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-ны хөрөнгө оруулж буй төслүүд нь тэдний Байгаль орчин ба нийгмийн бодлого (2006)-ыг баримталдаг бөгөөд энэхүү бодлогод нийгэм, байгаль орчны нөлөөллийг удирдах асуудлаарх дараах тусгай шаардлагууд тавигдсан байдаг. Эдгээрт:

- Гүйцэтгэлийн стандарт 1: Нийгэм, байгаль орчны үнэлгээ ба менежментийн систем;
- Гүйцэтгэлийн стандарт 4: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал;
- Гүйцэтгэлийн стандарт 5: Газар чөлөөлөлт ба албадан нүүлгэн шилжүүлэлт.
- Гүйцэтгэлийн стандарт 6: Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой байдлын менежмент.

ОТ нь ЕСБХБ - ны бодлого, гүйцэтгэлийн шаардлага 1, 4, 5 болон 6 (2006)-д нийцүүлэн ажиллах үүрэгтэй.

5 УДИРДЛАГЫН ХЯНАЛТ

Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд бэлчээрийн менежмент, малчдын амьжиргаанд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой тодорхойлсон эрсдэл, нөлөөллийг бууруулах удирдлагын хяналтын тоймлон оруулсан.

5.1 Бэлчээрийн менежмент болон амьжиргааг дэмжих стратеги (2017 – 2019)

Хүснэгт 4: Бэлчээрийн менежмент, амьжиргааг дэмжих стратегийн хэрэгжилтийн хураангуй (2017 – 2019)

#	ГГҮ	Зорилго, үзүүлэлт	Бодит үр дүн	Тайлбар
1	<ul style="list-style-type: none"> • Бэлчээрт сэргээн засварласан худгийн тоо; • Худаг ашигладаг малчдын тоо; 	<ul style="list-style-type: none"> • Түншлэгч сумдын бэлчээрийн хангамжийн ашиглалалыг сайжруулах усан 	<ul style="list-style-type: none"> • Түншлэгч сумдад 74 худгийг сэргээн засварлаж, 13 гар худгийг шинээр байгууллаа. Мөн Чандмана эрдэнэ 	ХДС-ийн санхүүжилтээр Аймгийн Хөдөө аж ахуйн газартай

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

	<ul style="list-style-type: none"> Худгаас усалдаг малын тоо 	<ul style="list-style-type: none"> Уст цэгийн тоог нэмэгдүүлэх замаар бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэх 	<p>төслийн хүрээнд 9 гүн өрмийн худаг барилаа.</p> <ul style="list-style-type: none"> Үетр автсан 16 гар худгийг малчдын хоршоотой хамтран сэргээн засварласан. 10 худгийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт холбож, 45 малчин өрхийн 13601 малын бэлчээрийн усны хангамжийг сайжрууллаа. 	хамтран хэрэгжүүлсэн.
2	<ul style="list-style-type: none"> Сургалтанд хамрагдсан малчдын тоо; Байгуулагдсан малчдын хоршооны тоо; Малчдын хоршоонд орсон айл өрхийн тоо 	<ul style="list-style-type: none"> Малчдын бизнес эрхлэх чадвар, зах зээлд нэвтрэх байдлыг сайжруулах Хоршоодын үйл ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Малчдын хоршоодод үйлдвэрлэл, худалдаа, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдад 18 хоршоо идэвхтэй ажиллаж байна. Ханбогд суманд нөлөөллийн малчин өрхийн амьжиргаа сайжруулах төсөл хэрэгжиж байна. 32 өрх Ангус үүлдрийн үхэр үржүүлэх, ногоо тарих, Гавилууд үүлдрийн хонь өсгөх төсөл хэрэгжүүлж байна. 	“Хөгжлийн шийдэл” ТББ зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.
3	<ul style="list-style-type: none"> Оролцоонд түшиглэсэн бэлчээрийн хяналт шинжилгээнд оролцсон нутгийн иргэдийн тоо; Бэлчээр ашиглалттай холбоотой санал гомдол, зөрчлийн тоо; Ханбогд сумын бэлчээрийн удирдлагын төлөвлөгөө; Зорилтот сумдын бэлчээрийн газрын зургийг боловсруулах; 	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн бэлчээрийн талбайг тогтвортой ашиглахтай холбоотой хүчин зүйлсийн талаар малчдын мэдлэг, ойлголтыг сайжруулах Бэлчээр ашиглалттай холбоотой зөрчлийг шийдвэрлэх тогтвортой арга барилын талаарх малчдын ойлголтыг сайжруулах 	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн малчдын оролцоотой байгуулагдсан Мөнх ногоон Галба ТББ бэлчээрийн хяналтыг хэрэгжүүлж байна. 41 талбайд бэлчээр/ ургамлын хээрийн хяналт шинжилгээ явуулсан. 4 суманд Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, аймгийн хэмжээний бэлчээр ашиглалтын зааврыг бэлтгэлээ. 	ХДС-ийн санхүүжилтээр дотоодын зөвлөх байгууллагатай гэрээлэн ажиллаж байна. Виктор Мап ТББ, Грийн Голд, WCS
4	<ul style="list-style-type: none"> Сургалтанд хамрагдсан малын эмчийн тоо Мал эмнэлгийн үйлчилгээний үйл ажиллагааны тоо 	<ul style="list-style-type: none"> Малын эрүүл ахуй, эрүүл мэндийг сайжруулах Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах 	<ul style="list-style-type: none"> Ханбогд суманд Малын эрүүл мэндийн төв байгуулж, техник тоног төхөөрөмжөөр хангасан. Тус төв нь Хүнс хөдөө аж ахуйн яамны Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн удирдлага доор ажиллана. Малын ариутгал халдваргүйтэлийн төсөл хэрэгжүүлж, 31 малын эмчийг сургалтанд хамрууллаа. 	ХДС-ийн санхүүжилтээр Аймгийн хөдөө аж ахуйн газартай хамтран ажиллаж байна.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

5	<ul style="list-style-type: none"> • Технологийн сургалтын тоо 	<ul style="list-style-type: none"> • Мал сүргийн менежментийн талаар малчдын мэдлэгийг дээшлүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Нөлөөллийн малчин өрхүүдийг хамруулан ногоо тарих, гагнуур хийх, хөдөө аж ахуйн бизнес, мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийн 12 сарын сугалтыг зохион байгуулсан. 	Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран ажиллаж байна.
6	<ul style="list-style-type: none"> • Малчдад чиглэгдсэн үйл ажиллагаа төслийн тоо 	Малчдын бизнесийн ур чадварыг сайжруулах	<ul style="list-style-type: none"> • “Эрүүл малчин” төслийг Ханбогд суманд хэрэгжүүлж, хөдөө орон нутгийн 543 малчдыг эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээнд хамрууллаа. • “Залуу малчин” хөтөлбөр хэрэгжүүлж, 237 залуучуудыг амьдрах ухааны сургалтанд хамруулж, 32 гишүүнтэй 4 бүлэг идэвхтэй ажиллаж байна. • Нөлөөллийн өрхийг хамруулсан оёдол, ангус үхэр үржүүлэх, өндөг, тахианы аж ахуй, ногоо тарих зэрэг чиглэлээр амьжиргаа сайжруулах төсөл хэрэгжүүлж байна. 	Өмнөговь аймаг болон түншлэгч сумдын Засаг даргын тамгын газартай хамтарч ажилласан.

Орон нутгийн байгууллага, нутгийн иргэдэд мэдлэг чадавхи олгох замаар тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор ОТ-н бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг сайжруулах санал санаачлага, үүрэг амлалтыг ихэнх тохиолдолд ХАГ-ний хүрээнд хэрэгжүүлнэ.

2015 онд, Орон нутгийн харилцааны баг удирдлагын хяналтыг хэрэгжүүлэх механизмыг өөрчлөх зэргээр төслийн хэрэгжилтээс орон нутагт мэдлэг чадавхи олгоход анхаарлыг хандуулах стратегийн өөрчлөлт хийсэн. Дараах гол зарчмуудыг дагаж мөрдөнө:

- Аливаа илрүүлсэн, шууд болон шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах удирдлагын хяналтыг ОТ хэрэгжүүлж, дангаараа хариуцана.
- Төслийн шалгуур үзүүлэлт, засаглалын шаардлагыг хангасан тохиолдолд ирээдүйн нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн аливаа төсөл, хөтөлбөрийг ХАГ болон ХДС-гаар дамжуулан удирдан зохицуулна (БОННУ-ний аудитаар шалгана)
- Удирдлагын хяналтыг тогтоогоогүй, ХАГ болон ХДС-гийн аль ч хөтөлбөрт хангалттай хэмжээнд авч үзээгүй, ирээдүйд илрэх шууд сөрөг нөлөөллийг ОТ хариуцана.

5.2. Бэлчээрийн менежмент, амьжиргаа дэмжих стратеги (2020 – 2022)

2018 оноос эхлэн ОТ компанийн Бэлчээрийн менежмент, амьжиргаа сайжруулах стратегид шинэчлэлт хийж, Орон нутгийн хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих стратеги (ОНХААБДС) боловсрууллаа. ОНХААБДС нь (Хавсралт 1) орон нутгийн хөдөө аж ахуйн тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг дэмжиж, орон нутгийн эдийн засгийг солонгоруулах, орон нутгийн

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

иргэдийн хүнсний аюулгүй байдлыг хангахад зорьж ажиллана. Энэхүү стратеги нь бүс нутаг дах бизнесийн үйл ажиллагааны тэтэлт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж буй чиг хандлагыг хөдөө орон нутгийн малчдын ахуй амьжиргааг сайжруулах болон орон нутгийн ханган нийлүүлэлтийг хөгжүүлэх талаар ОТ компанийн хэрэгжүүлж буй хүчин чармайлтыг уялдуулах зорилготой юм.

Стратегийн хэрэгжилтийг хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хангах ба орон нутгийн хөдөө аж ахуйн байгууллагууд болон малчин иргэдийн бизнесийн чадавхийг бэхжүүлж, тогтвортой хөгжлийг дэмжиж ажиллана. Стратеги нь дараах дөрвөн бүрдэл хэсэгтэй:

- Засаглал, хяналтын тогтолцоог бэхжүүлэх – Ханбогд сумын Малын эрүүл мэндийн төв
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх – Ангус үүлдрийн үхэр, жимс ногооны үйлдвэрлэл, Тогтвортой ноолуур төсөл, Гавилууд үүлдрийн хонь, тэмээний сүүн бүтээгдэхүүн
- Нэмүү өртөг үйлдвэрлэх – Мал нядалгааны цех, сүү цагаан идээ
- Зах зээл, тээвэрлэлт – Малчны зах, зах зээлд оролцогч талууд

ОНХААБДС –ийг Гурван талт зөвлөлийн Малчдын гомдол барагдуулах гэрээ, Малчдын амьжиргааг сайжруулах хөтөлбөр болон Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилттэй уялдуулж, таван үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хэрэгжилтийн шатанд хөдөө аж ахуйн салбарын хөгжилд оролцогч талуудын хамтын хүчин чармайлтаар хүлэээгдэж буй үр дүндээ хүрэх боломжтой. Эхний үе шатанд, хэрэгжилтийг хангах үндэс суурийг бүрдүүлэхийн тулд шаардлагатай судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэнэ. Дараагийн шатанд бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт болон засаглалын бүрдэл хангах, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа хийгдэнэ.

Төлөвлөсөн ажлын хүрээнд дараах хяналтыг арга хэмжээг 2020-2021 онуудад хэрэгжүүлнэ.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

Хүснэгт 5: Удирдлагын гол хяналт (2020-2021)

ID	Сэдэв	Хамаарал/үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Баталгаажуулах арга зам	Хариуцах тал
1.	Малчин айл өрхийн газарзүйн болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт	Барилга Үйл ажиллагаа Уурхайн хаалт	<ul style="list-style-type: none"> • Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт. • 2006, 2010 онд нүүлгэн шилжүүлсэн малчин өрхийн судалгаа, хяналт. • Мал аж ахуйг тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг. • ГТЗ нүүлгэн шилжүүлсэн малчин өрхүүдэд авах арга хэмжээний зөвшилцөл. • Амьжиргаа дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт 	<p>Малчин өрхүүдтэй Нөхөн олговор өгөх, нүүлгэн шилжүүлэх гэрээ байгуулах</p> <p>Малчин өрхийн нөхөн олговрын гэрээний хэрэгжилтийн жилийн хяналт шалгалт</p> <p>Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн үнэлгээ, гүйцэтгэлийн аудитын тайлан</p> <p>Сумын жилийн тайлан</p> <p>ОТМШБ болон гуравдагч талын тайлан</p> <p>ХДС-гийн төслийн тайлан</p>	Орон нутгийн харилцааны хэлтэс

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв	Хамаарал/үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Баталгаажуулах арга зам	Хариуцах тал
3	Мал маллах үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулах	Барилга Үйл ажиллагаа Уурхайн хаалт	<ul style="list-style-type: none"> • Сумын засаг захиргаа, малчидтай тогтмол хамтран ажиллаж, зөвлөлдөх байдлаар Ханбогд сумын Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх • Говийн оюу ХДС-гаар дамжуулан нэмэлт орлогын эх үүсвэртэй болох малчдын бүлэг, хоршоодын санал санаачлагыг (эко аялал жуулчлал, газар тариалан, байгаль орчны төсөл хэрэгжүүлэх) дэмжих. • Ханбогд сумын эмнэлэгтэй хамтран “Эрүүл малчин” төслийг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх • Малчдын хоршоо, бүлгийн ирээдүйн удирдагч, менежерийг бэлтгэх “Залуу малчин” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх 	Оролцогч талуудын хамтын ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөө Сумын жилийн тайлан ХДС-гийн төслийн тайлан	Орон нутгийн харилцааны хэлтэс
4	Малын эрүүл мэнд, ашиг шим буурсан	Барилга Үйл ажиллагаа Уурхайн хаалт	<ul style="list-style-type: none"> • Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон түншлэгч сумдтай хамтран мал сүргийн эрүүл мэндийн талаарх санал санаачлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (мал сүрэг болон өвөлжөө бууц халдваргүйжүүлэх төсөл) • ХАГ болон ХДС-гаар дамжуулан Ханбогд сумын Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх • Ханбогд суманд Сум дундын малын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх, Улсын мал эмнэлгийн газартай хамтран ажиллах 	Аймгийн жилийн тайлан Сумын жилийн тайлан ХДС-гийн төслийн тайлан	Орон нутгийн харилцааны хэлтэс Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын хэлтэс

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв	Хамаарал/үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Баталгаажуулах арга зам	Хариуцах тал
5	Бэлчээргүй болох, бэлчээр доройтох	Барилга Үйл ажиллагаа Уурхайн хаалт	<ul style="list-style-type: none"> Бэлчээрийн газрыг хөндөх явдлыг бууруулах, хөндөгдсөн газрын техник болон биологийн нөхөн сэргээлтийг тасралтгүй гүйцэтгэх, газар хөндөх зөвшөөрлийн системийг багтаасан Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх. Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилт 	Газар хөндөх зөвшөөрлийн бүртгэл ОТ геологийн мэдээллийн сан, Нөхөн сэргээлтийн бүртгэл, тайлан	Байгаль орчин, биологийн олон янз байдлын хэлтэс
			<ul style="list-style-type: none"> Орчны агаарын тогтмол хяналтын хөтөлбөрийн хүрээнд агаарын чанар тодорхойлогчийг хянадаг Агаарт ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилт Ургамлын бүрхэвчид их хэмжээний тоос үүсэж бэлчээрийг доройтуулахаас сэргийлэх зорилгоор тоосжилт үүсэх магадлал өндөртэй үйл ажиллагаанд зохих тоосжилт хянах арга хэмжээ хэрэгжүүлэх 	Агаарын чанарын хяналтын тайлан Байгаль орчны менежментийн жилийн тайлан	Байгаль орчин, биологийн олон янз байдлын хэлтэс
			<ul style="list-style-type: none"> Замгүй газраар машинаар явах эсхүл хөндсөн/эвдэрсэн газарт бусад үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаарддаг Тээвэрлэлтийн удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилт 	Тээвэрлэлтийн удирдлагын төлөвлөгөө Аялалын удирдлагын систем	Үйл ажиллагаа, дэд бүтцийн хэлтэс
			<ul style="list-style-type: none"> Ханбогд сумын Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн хэлтэс болон түншлэгч сумдуудтай хамтран бэлчээр сайжруулах санал санаалагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Холбогдох оролцогч талуудтай тогтмол хамтран ажиллаж, зөвлөлдөх 	ХДС-гийн төслийн тайлан Бэлчээрийн хяналтын тайлан, Ханбогд сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөө Оролцогч талуудын хамтын ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөө, өргөдөл гомдлын бүртгэл	

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв	Хамаарал/үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Баталгаажуулах арга зам	Хариуцах тал
					Орон нутгийн харилцааны хэлтэс
6	Уст цэгт хүрэхэд хязгаарлалт үүсэх, уст цэггүй болох	Барилга Үйл ажиллагаа Уурхайн хаалт	<ul style="list-style-type: none"> • Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилт • Малчдын худагт нөлөөлөхөөс зайлсхийх үүднээс ус хангамжийн системийг загварчлах. • Төслийн байгууламжийн орчимд нөлөөлөлд өртсөн малчдын бүх худгийг хянах. • Нөлөөллийг эртнээс илрүүлэх үүднээс урт хугацааны хяналтыг үргэлжлүүлэх; • Гүний хоолойн гүний ус олборлох үйл ажиллагаанаас малчдын худагт нөлөөлөх тохиолдолд гидрогеологийн үнэлгээ хийж, шалтгааныг тогтоон, орон нутгийн оролцогч талуудтай зөвлөлдөн үр дүнтэй бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна. 	<p>Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө</p> <p>Усны хяналт шинжилгээ</p> <p>Чандмана эрдэнэ төслийн тайлан</p>	<p>Байгаль орчин, биологийн олон янз байдлын хэлтэс</p>
			<ul style="list-style-type: none"> • Оролцогчдод усны нөөцийг өөрсдөө хянах боломж олгох, хяналт шинжилгээний хариуг хамтран хэлэлцэхэд оролцох зэргээр орон нутгийн малчдыг хамруулсан Оролцоонд түшиглэсэн усны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 	<p>Оролцоонд түшиглэсэн усны хяналт шинжилгээний тайлан</p>	<p>Орон нутгийн харилцааны хэлтэс</p>

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв	Хамаарал/үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Баталгаажуулах арга зам	Хариуцах тал
			<ul style="list-style-type: none"> Ханбогд сумын Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд усны нөөцийг сайжруулах төсөл/хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ХАГ болон ХДС-гаар дамжуулан Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдад бэлчээрийн усны нөөцийн цогц судалгаа явуулахад дэмжлэг үзүүлэх ХАГ болон ХДС-гаар дамжуулан малчдын бүлэг, хоршоодын гар ажиллагаатай худаг сэргээн засварлах санал санаачлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх 	Сумын жилийн тайлан ХДС-гийн төслийн тайлан	Орон нутгийн харилцааны хэлтэс

Тайлбар: Гүйцэтгэгчид тавих биологийн олон янз байдлыг хамгаалахтай холбоотой шаардлагуудыг тусдаа гэрээ, ажлын багцын хамрах хүрээг боловсруулах ажлын хүрээнд явуулсан эрсдэлийн үнэлгээгээр дамжуулан гүйцэтгэгчийн оролцооны явцад тодорхойлсон. Биологийн олон янз байдлын (илрүүлсэн бусад олон асуудлын хамт) талаарх асуудалтай холбоотой шаардлагыг гэрээ тус бүрийн хамрах хүрээнд тусгасан. Гүйцэтгэгчдэд шаардлагатай сургалтыг явуулж, гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг ОТ хянаж, аудит хийж, шалгана. Дэлгэрэнгүй мэдээллийг Гүйцэтгэгчийн оролцоо, хамтын ажиллагааны хамрах хүрээнд тусган оруулсан.

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

6 ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ

6.1 Удирдлагын төлөвлөгөөг хянах, засвар оруулах

Энэхүү удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутам хянан үзэж, өөрчлөгдөж буй нөхцөл байдал болон ОТ-н үйл ажиллагааны шаардлагыг тусган шинэчилж байна. Энэхүү удирдлагын төлөвлөгөө болон гарын авлагыг өөрчлөх, засвар оруулах үүргийг төлөвлөгөөг эзэмшигч Орон нутгийн харилцааны хэлтсийн Ерөнхий менежер хүлээнэ.

Хэрэв үйл ажиллагааны журамд бодит өөрчлөлт шаардлагатай (ОТ-н Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны менежментийн системд байдаг Өөрчлөлтийн менежментийн журамд тодорхойлсны дагуу) бол энэхүү удирдлагын төлөвлөгөөг “шаардлагын дагуу” өөрчилж болно.

Тус удирдлагын төлөвлөгөөнд оруулах аливаа өөрчлөлт/засварыг ОТ Порталд оруулж, ОТ-н бүх ажилтан, бусад талууд удирдлагын төлөвлөгөөний хамгийн сүүлийн хувилбартай танилцах боломж олгоно.

Хүснэгт 6. 2020-2021 онд хэрэгжүүлэх гол үе шат

Үйл ажиллагаа	Зорилтот огноо/хугацаа	Үр дүн
Ханбогд сумын Сум дундын Малын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлэх,, Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн хэлтэс болон Улсын Мал эмнэлгийн ерөнхий газарт тус төвийг ажиллуулах чадавх бий болгоход дэмжлэг үзүүлэх.	2020 оны 2-р улирал	Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран ажиллах гэрээ
Говийн оюу ХДС-гийн санхүүжилтээр Ханбогд суманд өвс төжөөлийн агуулах байгуулах	2020 оны 1-р улирал	Төслийг Говийн оюу ХДС-д хүргүүлсэн
Говийн оюу ХДС-гаар дамжуулан нэмэлт орлогын эх үүсвэртэй болох малчдын бүлэг, хоршоодын санал санаачлагыг (оёдол, газар тариалан, өндөр ашиг шимтэй үүлдэр үржүүлэх, тахианы төсөл хэрэгжүүлэх) дэмжих.	2020 оны 3-р улирал	Хийгдэж байгаа
Ханбогд суманд махны цех барих	2021 оны 3-р улирал	Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байна.
Ханбогд суманд Малчдын захыг байгуулах ажлыг дэмжих	2022 оны 4-р улирал	Төлөвлөж байгаа

7 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

7.1 Хяналт шинжилгээний шаардлагын ерөнхий тойм

Төслийн стандартад нийцсэн байдлыг (4-р хэсэг: *Төслийн стандартаас харна уу*) үнэлэх зорилгоор үйл ажиллагааны шатанд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний арга хэмжээг энэ хэсэгт тодорхойлов.

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

Хяналт шинжилгээгээр Төслийн стандартад нийцээгүй зөрчил илэрвэл тэдгээрийг шалгаж, зохих засах арга хэмжээг тодорхойлно (Элемент 14 ОТ-н ЭМААБОАБ-ын УС-ийн Үл тохирол, осол зөрчил болон хариу авах арга хэмжээний удирдлагаас харна уу). ОТ, төслийн зээлдэгч нар болон биологийн олон янз байдлын зөвлөх/гүйцэтгэгчдийн зөвшөөрсөн урьдчилсан арга барилаар нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын шинж чанарын Гүйцэтгэлийн гол үзүүлэлт, хяналт шинжилгээний босгыг тодорхойлсон бөгөөд тухайнбосгоос хэтэрсэн тохиолдолд хэрэгжүүлэх боломжтой удирдлагын хяналт шалгалт, арга хэмжээг эхлүүлнэ (БОЯБХШҮТ-с харна уу).

7.2 Гүйцэтгэлийн гол үзүүлэлт

Хүснэгт 7: Гүйцэтгэлийн гол үзүүлэлт

ID	Гүйцэтгэлийн гол үзүүлэлт	Зорилт
LD-KPI 01	Энэхүү удирдлагын төлөвлөгөөний холбоотой бүртгэгдсэн үл нийцэлийн тоо.	Амьжиргаагаар холбоотой зөрчлийн тоог бууруулах, тасралтгүй сайжруулах.
LD-KPI 02	Бэлчээр, ус, малчдын амьжиргааны талаарх иргэдийн өргөдөл, гомдлын тоо.	Малчдын гомдолыг барагдуулах, нөхцөлийг сайжруулах
LD-KPI 03	Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжилт Говийн оюу ХДС болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн бэлчээр, малчдын амьжиргааг дэмжих төсөл, хөтөлбөрийн тоо	Ханбогдын сум дундын Малын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлэх Говийн оюу ХДС-гаас санхүүжүүлсэн мал аж ахуйн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт
LD-KPI 04	Явуулын эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан малчдын тоо	“Эрүүл малчин хөтөлбөр” – ийн хэрэгжилт.
LD-KPI 05	Бэлчээр, мал аж ахуйд түшгилсэн амьжиргаагаа дэмжих бизнесийг хөгжүүлэх төслийн тоо/төрөл.	Жил бүр дэмжлэг авсан хоршоодын нийт тоо.
LD-KPI 06	Нөхөн сэргээсэн талбайг жилийн техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд багтсан талбайтай харьцуулсан үзүүлэлт	Зорилт – хэрэгжилт 100%
LD-KPI 07	Нөхөн сэргээсэн талбайг жилийн биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд багтсан талбайтай харьцуулсан үзүүлэлт	Зорилт – хэрэгжилт 100%

7.3 Хяналт шинжилгээний гол үйл ажиллагаа

Хүснэгт 8: Хяналт шинжилгээний арга хэмжээ

ID	Сэдэв	Арга барил	Давтамж/ хугацаа	Байршил
1	Газарзүйн байршлын болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд	<ul style="list-style-type: none"> Нүүлгэн шилжүүлсэн малчдын хэрэгжүүлсэн бизнесийн 	Жил бүр	Ханбогд сум

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

	өртсөн малчин өрхийн амьжиргаа	хөгжлийн төслийн хэрэгжилтийн байдал. <ul style="list-style-type: none"> Нүүлгэн шилжүүлэн малчин өрхийн амьжиргааны жилийн судалгаа Говийн оюу ХДС-гийн жилийн санхүүгийн тайлан 		
2	Бэлчээрийн нөхцөл, даац	<ul style="list-style-type: none"> Ус, цаг уурын хүрээлэнгээс гаргасан Ханбогд сумын бэлчээрийн даацын онлайн мэдээллийн сан. 	Жил бүр	Ханбогд сум (шаардлагатай бол бусад сум)
3	Малчдын хоршоод амьжиргаагаа сайжруулах зорилгоор бизнес хөгжүүлэх төсөл	Говийн оюу ХДС-гийн жилийн санхүүгийн тайлан	Жил бүр	Ханбогд сум (шаардлагатай бол бусад сум)
4	Усны нөөцийн бэлэн байдал, хүртээмж, усны чанар	<ul style="list-style-type: none"> Говийн оюу ХДС-гаас санхүүжүүлсэн гидрогеологийн үнэлгээний ажлын тайлан Хугацааны явцад усны чанар, хүртээмж буурсаныг тогтоосон малчдын худгийн хяналт шинжилгээний хариу 	Шаардлагын дагуу Жил бүр	Ханбогд сум Ханбогд сум, Гүний хоолойн талбай

8 СУРГАЛТ

8.1 Ерөнхий тойм

Танилцуулах сургалт (ерөнхий ойлголт өгөх) болон ажлын байранд тусгайлан зориулсан сургалтын хүрээнд шаардлагатай бүх сургалтыг явуулна.

8.2 Танилцуулах болон давтан сургалт

ОТ-н үндсэн болон ОТ-д ажиллах гүйцэтгэгчдийн бүх ажилтан ерөнхий танилцуулах сургалт, төслийн талбайн тусгай сургалт, орон нутаг, БАСМТ-ний талаар ойлголт өгөх тусгай сургалт зэрэг ЭМААБО-ны сургалтанд хамрагдана.

9 АУДИТ БА ТАЙЛАГНАЛ

9.1 Дотоод аудит

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг дотоодын хяналт шалгалт, аудитаар жил бүр хянан шалгана.

Үйл ажиллагааны салбар чиглэлийн ахлах мэргэжилтэн/ахлах ажилтнууд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны өргөн хүрээг хамруулан байнгын үзлэг шалгалт явуулна.

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

ЭМААБОАБ-ын хэлтэс Хяналтын хуудас ашиглан ээлжит үзлэг шалгалтыг нэмэлтээр хийж гүйцэтгэнэ.

Дээрх шалгалтын явцад илэрсэн аливаа осол зөрчлийг осол зөрчлийн менежментийн системд (14-р элемент) мэдээлнэ.

16-р элемент Гүйцэтгэлийн үнэлгээ, аудитын дагуу жилийн дотоод аудитын хөтөлбөрөөр тохирлыг хянан шалгана. Үүнийг ЭМААБО-ны менежментийн системийн шаардлагад (БОННБУ болон удирдлагын төлөвлөгөө багтсан) нийцсэн эсэхэд үнэлгээ хийх зорилгоор гүйцэтгэнэ.

Дээрх шалгалтын явцад илэрсэн бүх осол зөрчил, үл тохирлыг ОТ-н ЭМААБОАБ-ын менежментийн системийн шаардлагын дагуу мэдээлнэ.

Ханбогд сумын өрхийн жилийн судалгаа

ОТ-н Нийгмийн хариуцлагын баг шууд нөлөөлөлд өртсөн айл өрхүүдэд өрхийн тогтмол судалгааг явуулна. Ханбогд сумын малчин өрхүүдийн нийгэм эдийн засгийн байдлын ерөнхий хяналт шинжилгээг нүүлгэн шилжүүлсэн малчдын сонголтоор хийсэн хяналт шинжилгээнээс тасралтгүй явуулна. Энэ нь тогтвортой үйл ажиллагаа руу хийх шилжилт болон хоёрдогч нөлөөлөл зэрэг бүх нөлөөллийн хяналт шинжилгээтэй зэрэг хийгдэнэ.

9.2 Хөндлөнгийн аудит

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг Рио Тинтогийн аудит, баталгааны хөтөлбөр болон ОТ-н зээлдүүлэгчид тодорхой хугацаанд хянаж шалгана.

10 ТАЙЛАГНАХ

Энэхүү төлөвлөгөөнд хийсэн аудитын үр дүнг ОТ-н Гүйцэтгэх удирдлагын багт тайлагнана.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

11 БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Файлын нэр	ОТ-10-PLN-0013-М-Бэлчээрийн менежмент болон малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө
Тодорхойлолт	Бэлчээрийн менежмент болон болон малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө
Анхны зохиогч (нар)	Лувсангийн Баярбаатар
Үүсгэсэн огноо	2016.08.28
Баталсан	Шуркагийн Байгалмаа, Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий менежер
Баталсан огноо	2017.03.30
Өөрчлөлтийн бүртгэл	#

Эрсдэлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдэл үнэлэгч	Хянан засварлах хуваарь	Дараагийн хянан засварлах огноо
Дунд зэрэг	2016.09.01	Лувсангийн Баярбаатар	2 жил тутам	2021.11.14

Хянан засвар	Хянан засвар хийсэн огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварын тэмдэглэл
0.1	2016.09.29	Лувсангийн Баярбаатар	Шуркагийн Байгалмаа	Эхний хувилбарыг боловсруулав.
1.0	2017.02.24	Лувсангийн Баярбаатар	Шуркагийн Байгалмаа	Эхний хувилбарыг батлав.
1.1	2019.11.14	Лувсангийн Баярбаатар	Гончигжанцангийн Сугар	Энэхүү Удирдлагын төлөвлөгөөг шинэчилж, үйл ажиллагааны стратеги, гол үе шатууд, үүрэг хариуцлагад гарсан өөрчлөлтийг тусгалаа.

Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0013-М	Хувилбар: 1.1

ХАВСРАЛТ 1. ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИ

